

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ I УЛИРАЛЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025.04.07

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
133	326	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	УБЕГ нь Засгийн газрын 2022 оны 197, 207 дугаар тогтоолоор Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болон Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад багтсан, суурь мэдээллийн сан бүхий байгууллага бөгөөд Засгийн газрын 2023 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт"-д Улсын бүртгэлийн мэдээллийн сан байхгүй болно. Тус журам батлагдсанаас хойш улсын бүртгэлийн мэдээллийн сан шинээр үүсгэгдээгүй, бүтцийн өөрчлөлт ороогүй болно.	100		
145	338	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	1.. Төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд нийгмийн халамж, улсын бүртгэл, татварын харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг тусгахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт даалгасугай	ТатЕГ-ын дарга болон УБЕГ-ын даргын хамтарсан 2024.09.16-ны өдрийн А/204, А/161 дугаар тушаалын хавсралтаар "Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд нэмэгдүүлсэн хувиар албан татвар ногдуулах журам"-ыг баталсан. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актад 2024.09.16-ны өдөр 6959 дугаарт бүртгэгдсэн. Тус журмаар Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх хэсэгт Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8 дахь хэсгийг	100		

			хэрэгжүүлэх эрх бүхий аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилгын стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд тухай бүр цахим хэлбэрээр дамжуулах, Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь системд бүртгэх, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх харилцааг зохицуулж байна.			
339		2.. Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхад анхаарч ажиллаж байгаа бөгөөд, үүнтэй холбогдсон гомдол Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс уламжлан ирээгүй байна.	100		
340		3.Монгол Улсын иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэг болон киоск машинаар дамжуулан олгох боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар (П.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай	Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2025.03.31-ний өдрийн байдлаар Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 1,660,242 иргэнд тоон гарын үсэг олгосон. Үүнээс гар утсаар 770,834 иргэний үнэмлэхэд 889,408 (<i>Киоск машинаар 143,142</i>) Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 116 киоск машин, бусад байгууллагын 1,477 ширхэг цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон. Үүнд: Гэрэгэ системс ХХК-489	100		

				Голомт банк АТМ-аар -330 ХААН банкны АТМ-аар-442 ТҮЦ-100 Төрийн банкны 2 Киоск машинаар тоон гарын үсэг олгож эхлэхээр программ туршилтын ажил хийгдэж байна.			
		Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Танилт нэвтрэлтийн систем “ДАН”-ээр цахим үйлчилгээ авахад иргэн, хуулийн этгээдийг таньж баталгаажуулахад тоон гарын үсэг (G-sign)-ийг ашиглаж нэвтрэх боломжтой болгосон. Мөн Танилт нэвтрэлтийн систем “ДАН”-ээр тоон гарын үсэг (G-sign), нэг удаагийн код (OTP), банкны эрхээр тус тус нэвтрэхэд иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг ХУР системээр дамжуулан улсын бүртгэлийн сервисээр дуудаж баталгаажуулалт хийгдэж байна.	100		
Ерөнхий сайдын захирамж							
185	394	2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50	XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Улсын бүртгэлд 2021, 2022 онуудад бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн судалгааг гаргаж, НДЕГ, ТатЕГ- т тус тус хүргүүлж, нийгмийн даатгал болон татвар төлөлтийн талаарх мэдээллийг авч, нэгтгэн судалгаа хийсэн. Дээрх байгууллагууд нь гэрээний дагуу улсын бүртгэлийн мэдээллийг цаг алдалгүй “ХУР” системээр дамжуулан авч байна. Цаашид ЦХИХХЯ-тай хамтран ажиллах 2025 оны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	100		
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
244	537	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр	39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн	Онц чухал дэд бүтэцтэй байгууллага тул хоёр жил тутамд Тагнуулын ерөнхий газраас мэдээллийн систем, сүлжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитыг 2024 оны 05 дугаар сард хийлгэж мэдээллийн аюулгүй байдлын хувьд “Маш өндөр”	100		

		тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	түвшний эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Эрсдэлийг буруулах зорилгоор 2024.09.27-ны өдөр Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн төлөвлөгөөг нууцын түвшинд батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар хэрэгжилт 30 хувийн хэрэгжилттэй, 2025 төсөвт үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардал 742,0 сая төгрөг төсөвлөж, ХЗДХСайдаар батлуулсан 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 469,0 сая төгрөгөөр нууцын зэрэглэлтэй тоног төхөөрөмж, программ хангамжийн төсвийг батлуулсан.			
		2024_44. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл / 2025-01-18 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	44.22.3.6. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын бүртгэлийн үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, “И-Монгол академи” УТҮГ (Б.Мягмарнаран)-г;	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бусад хуулийн этгээдийн улсын бүртгэлийг Төрийн үйлчилгээний цахим портал /e-business/-аар дамжуулан 11 төрлийн лавлагаа, 42 төрлийн үйлчилгээг тус тус үзүүлж байгаа бөгөөд 2023.04.07-ны өдрөөс 2025.03.31-ны өдөр хүртэлх хугацаанд 26,353 лавлагаа, 123,847 үйлчилгээг үзүүлсэн байна. Цаашид И-Бизнес платформоор үзүүлж байгаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сайжруулах зорилгоор ЦХИХХЯ-тай хамтран дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд: Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг AI ашиглан автоматжуулах программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх, турших, хэрэглээнд нэвтрүүлэх.	100		

				И-Бизнес платформоор ирүүлсэн хуулийн этгээдийн хүсэлтийг хуулийн этгээдийн ERS системтэй холбох			
Нийт хувь					100		
Оноо					5		